


МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

“Оюу толгой” ХХК-ийн 2021 оны II улирлын тойм мэдээ

OTMongolia OTMongolia Oyu Tolgoi OTMongolia OTMongolia

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Аюулгүй ажиллагаа нь бидний нэн тэргүүний зорилт. Аюултай гэж үзсэн ямар ч ажлыг ажилтан бүр шууд **зогсоох** эрхтэй.



2021 оны хоёрдугаар улиралд

12,121,723

Хүн/цаг

2021 оны хоёрдугаар улирлын байдлаар гэмтэл, бэртийн давтамжийн үзүүлэлт 200,000 хүн/цаг тутамд 0.14 ногдож байгаа нь Рио Тинто группийн хэмжээнд аюулгүй ажиллагааг сайн хангадаг уурхайн нэг болж байна.

Гүйцэтгэл
0.14

Ноцтой эрсдэлийн удирдлага



57,240
Магадлагаа

Амь хамгаалах зорилготой “Ноцтой эрсдэлийн удирдлага” хөтөлбөрийн хүрээнд 57,240 магадлагаа хийлээ.

МОНГОЛ АЖИЛТНУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Үүрэг 90%

96%



Нийт ажиллах хүчний 96 хувийг монгол иргэд бүрдүүлж байна. Үүнээс 26,4 хувь нь гүний уурхайн төслийн ажилтнууд юм.

БОЛОВСРОЛ СУРГАЛТ

(Нийт хүн/цаг)



Нийт 175,259 хүн/цагийн сургалтад ажилтнуудаа хамруулан ур чадварыг нь өсгөсөөр байна.



БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР

(Тэтгэлэг, бусад хөтөлбөрүүд)

2011 оноос хойш
3,457 оюутан,



ЗАЛУУСЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

2013 оноос хойш ахлах ангийн **1,180** сурагч,




“ГОВИЙН ОЮУ” САН, МАЛЧНЫ ХҮҮХДИЙН ТЭТГЭЛЭГ

2015 оноос хойш Өмнөговийн **342** оюутан тус тус хамрагджээ.

ҮНДЭСНИЙ ХУДАЛДАН АВАЛТ


(2010 - 2021/02 улирал, сая ам.доллар)



2021 оны эхний хагаст үйл ажиллагааны худалдан авалтын баг 628 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 407 нь үндэсний компаниуд байв. Эдгээр үндэсний компаниуд худалдан авалтынхаа 75 хувийг зарцуулав. 2010-2021 оны хоёрдугаар улиралд үндэсний худалдан авалтад 3.7 тэрбум ам.доллар зарцуулсан.


УСНЫ ХЭРЭГЛЭЭ

(Нэг тонн хүдэр боловсруулахад зарцуулсан усны хэмжээ, шоо метр, сараар)



УС ДАХИН АШИГЛАЛТ

(хувь, сараар)



1.2м³



0.3м³

Нэг тонн хүдэр боловсруулахдаа 0.34м³ буюу дэлхийн ижил төрлийн уурхайнуудын ашиглалтын дунджаас даруй гурав дахин бага ус ашиглаж байна.

УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

(2013 - 2021/02 улирал)



2021 оны хоёрдугаар улиралд зорилтоо давуулан биелүүлж ус дахин ашиглалтын түвшинг дунджаар 89.1 хувьд хүргэв.


МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

"Оюу толгой" ХХК-ийн 2021 оны II улирлын тойм мэдээ

OTMongolia OTMongolia Oyu Tolgoi OTMongolia OTMongolia

ТАТВАР, ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨР

(2010 - 2021/02 УЛИРАЛ, САЯ АМ.ДОЛЛАР)



2010-2021 оны хоёрдугаар улиралд өсөн нэмэгдсэн дүнгээр


3.4

ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫГ татвар хураамж, бусад төлбөрт төлжээ.

ДОТООДОД ЗАРЦУУЛСАН НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГӨ

(2010 - 2021/02 УЛИРАЛ, ТЭРБУМ АМ.ДОЛЛАР)

2010-2021 оны хоёрдугаар улиралд үндэсний компаниудтай хийсэн худалдан авалт, төсөвт төлж буй татвар, хураамж, үндсэн ажилчдын цалин 12.7 тэрбум ам.доллар давлаа.




2010 - 2021 оны хоёрдугаар улиралд татвар, хураамж, үндэсний компаниудад төлсөн НӨАТ зэрэг бусад төлбөрт 3.4 тэрбум ам.долларыг төлсөн. 2021 оны эхний хагаст татвар, хураамж бусад төлбөрт 503 сая ам.доллар төлжээ.

* "Оюу толгой" ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.

** Энэ дүнд олон улсын арбитраж хэлэлцэж буй 356 сая ам.долларын төлбөр багтсан болно.

ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД


(сая ам.доллар)



2021 оны эхний хагаст тогтвортой хөгжилд чиглэсэн төслүүдэд 3.4 сая ам.долларын санхүүжилт олгожээ.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ХУДАЛДАН АВАЛТ


(2010 - 2021/02 улирал, сая ам.доллар)



2021 оны эхний хагаст Өмнөговь аймагт бүртгэлтэй 85 ханган нийлүүлэгч манайд бараа, үйлчилгээ нийлүүлэв. 2010-2021 оны хоёрдугаар улиралд Өмнөговь аймгийн хэмжээнд хийсэн худалдан авалтад нийт 744 сая ам.доллар зарцуулжээ.

ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ ЗЭСИЙН ХЭМЖЭЭ


(мян.тонн)



2021 оны хоёрдугаар улиралд 36,735 тонн баяжмал дахь зэс үйлдвэрлэв. 2021 оны 150,000 – 180,000 тонн баяжмал дахь зэс үйлдвэрлэх төлөвлөгөөний биелэлт хангалттай байна.

ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ АЛТНЫ ХЭМЖЭЭ


(мян.унц)



2021 оны хоёрдугаар улиралд 113,054 унц баяжмал дахь алт үйлдвэрлэв. 2021 онд 400,000 – 480,000 унц баяжмал дахь алт үйлдвэрлэх төлөвлөгөөний биелэлт хангалттай байна.

ГҮНИЙ УУРХАЙН ХӨНДЛӨН НЭВТРЭЛТ

(метр, сараар)



2021 оны хоёрдугаар улиралд гүний уурхайн хөндлөн малталтын гүйцэтгэл 1707.6 метр, харин налуу амны малталтын ажил 646.7 метрийн ахицтай байлаа.